									-НТХО болон НОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 19 төсөл арга хэмжээ, 72.4 тэрбум төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна. Мөн Гадаадын зээл, тусламжийн хүрээнд МУЗГ, НЗДТГ болон Германы хамтын ажиллагааны GIZ төсөлтэй хамтран Улаанбаатар хотын Угсармал орон сууцны зарим барилгад дулааны тоолуур суурилуулах, үүнтэй холбоотой программ хангамж хийх, мэдээллийн сан үүсгэх зорилго бүхий 2 багц 2.4 тэрбум төгрөгийн ХАА-г зохион байгуулж гэрээ байгуулан ажиллаж байгаа үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
230	Албанаас Улс, нийслэл, ОНХСХ болон бусад эх үүсвэрээс худалдан авах ажиллагааг зохион байгуулах.	-	Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувь	100%	100%				Тус албанд 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 6, Нийслэлийн төсвийн 17, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10, Зээл буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар 2, байгууллагын урсгал зардлаас 73 ажил худалдан авах ажиллагаа зохион байгуулсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 3 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж тендер хүлээн авч байна. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн хувь 97 байна.
Зорилт 73 Худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулж, бизнес эрхлэгчдийг дэмжих									
231	Зөвшөөрлийн тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидаг согтуурахтай тэмцэх тухай хууль (шинэчилсэн найруулга), тэдгээрт нийцүүлж гаргасан журмыг худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд сурталчилна.	-	Сургалтад хамрагдсан худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эзлэх хувь	0	50				Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/219 дүгээр захирамжаар Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс дүүргүүдийн Засаг дарга нарт шилжүүлсэнтэй холбогдуулан 9 дүүргийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээллийн

							Улаанбаатар.mn цахим хуудасны "Онлайн бизнес төв"-өөр хүсэлт илгээх заавар зөвлөмжийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл тус бүрээр байршуулан бизнес эрхлэгчдэд хүргэж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/262 дугаар тушаалаар "Онлайн бизнес төв"-ийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системээр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй цахим үйлчилгээ, түүнтэй холбоотой систем хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон "Онлайн бизнес төв" 2.0 хувилбар платформыг нэвтрүүлэх ажлын техникийн даалгаварт төсөл боловсруулан санал хүргүүлээд байна. Монгол улсын Эдийн засаг хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох зэрэг тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд эрх бүхий этгээдийн тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, цахимжилтаар шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий холбогдох байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэгт ажиллаж, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх, Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны процессын зураглал, дэлгэрэнгүй тайлбарыг загвар маягтын дагуу гаргаж, хүргүүлээд байна
232	Худалдаа, үйлчилгээний газруудад UCS 1201B "Худалдаа үйлчилгээний гадна орчны ерөнхий шаардлага", UCS 1202B "Худалдаа	-	Стандартын шаардлага хангасан худалдаа, үйлчилгээний газрын эзлэх хувь	-	20	Баянзүрх дүүргийн 3, 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай Баян цээл худалдааны төв, Сансар орчимд хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд 2024.01.22-ны өдөр Хотын стандарт, хяналтын газартай хамтран	100%

үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавигдах ерөнхий шаардлага", UCS 1201C "Худалдаа үйлчилгээний газрын нэр, үйлчилгээний мэдээлэл, гадна зар сурталчилгаа тавигдах шаардлага" стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.				Худалдаа, үйлчилгээний газруудад UCS 1201B "Худалдаа үйлчилгээний байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага", UCS 1202B "Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавигдах ерөнхий шаардлага", UCS 1201C "Худалдаа үйлчилгээний газрын нэр, үйлчилгээний мэдээлэл, гадна зар сурталчилгаа тавигдах шаардлага" стандартын сурталтыг зохион байгуулж, барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг 45 аж ахуйн нэгжид хүргүүлж стандартын шаардлагыг хангуулсан. Стандарт хэмжилзүйн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн С/17 дугаар тушаалаар баталсан MNS 5021-1-52024 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага стандартыг нийслэлийн нутаг дэвсгэрт жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчлах, мэдээлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах чиглэлийг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хот байгуулалт, хотын стандартын газарт УБ хотын Ерөнхий менежерийн 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 01/1175 тоот албан бичгээр хүргүүлж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн дагуу НХХААГ-аас Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн ажлын байрны дүгнэлт авах /талбайн хэмжээ 51м2/ стандартад хүрэхгүй хүсэлт гаргасан 174 худалдааны газар, хүсэлтээ гаргаагүй 288 нийт 462 худалдааны газар согтууруулах ундаа худалдах зөвшөөрөл олгох боломжгүй байсан бөгөөд MNS 5021-1-52024 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий
--	--	--	--	---

							шаардлага стандарт батлагдсанаар үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх боломж бүрдсэн.	
233	Үйлдвэрлэлийн зохистой дадлын талаар үйлдвэрлэл эрхлэгчдэд сургалт зохион байгуулна.	-	Мэдлэг чадвараа дээшлүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийн тоо	-	500		Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэгт "энэ хуулийн 25.2-т заасан хариуцлагатай үйлчилгээ явуулах журам, хариуцлагатай үйлчилгээний жишиг төлбөрийн хэмжээг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Журам болон жишиг төлбөрийн хэмжээг батлах тухай" А/04 дүгээр тушаал батлагдсан. Тус тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалт эрхлэх журам"-ийн 2.3-т журмын 2.2-т заасан жишиг хөтөлбөр модулийг аймаг, нийслэлийн Засаг дарга батална." гэж заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн "Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/209 дүгээр захирамж гарсан. Захирамжаар согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийг холбогдох хууль, журам, захирамжийн хүрээнд шийдвэрлэн тайлагнаж ажиллахыг УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албанд үүрэг болгосны дагуу УБ хотын Ерөнхий менежерийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн "Сургалт эрхлэн явуулах эрх олгох тухай" А/155 дугаар тушаалаар сургалтад хамрагдаж тэнцсэн элсэгчдэд олгох гэрчилгээний загвар болон сургалт эрхлэн явуулах 6 төрийн бус байгууллагыг баталж, хамтран ажиллаж байгаа бөгөөд дээрх төрийн бус байгууллагууд нь 2024 онд нийт 2811 ажилчдыг сургалтад хамруулж гэрчилгээ олгосон байна. Үүнд: 1. Боловсрол ирээдүйн хөгжлийн гарч ТББ	100%

						2. Монголын боловсролын салбарын удирдах ажилтны холбоо ТББ 3. Хөгжлийн хөтөч ОЗХ ТББ 4. Сogтyууpyулax yндaаны зөв зохистой хэрэглээний соёлыг түгээх холбоо ТББ 5. Эрхэт төгс эрдэм холбоо ТББ 6. Монголын үндэсний хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн нэгдсэн холбоо ТББ Мөн Сogтyууpyулax yндaаны хариуцлагатай үйлчилгээний сургалт зохион байгуулсан тухай тайлан мэдээг 2 удаагийн албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн ажиллаж байна. Үүнд: 1.2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 01/426 дугаартай албан бичиг; 2.2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 01/1921 дугаартай албан бичиг.	
234	Согтyууpyулax yндaагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад аяга таваг ариутгах төхөөрөмжийг холбогдох стандартыг нэвтрүүлж, мөрдүүлэх.	-	Аяга таваг ариутгах төхөөрөмж нэвтрүүлсэн газрын эзлэх хувь	10	30	Согтyууpyулax yндaаны эргэлтэд хяналт тавих, архиван согтyуpaxтaй тэмцэх тухай хуулийн 151 дүгээр зүйлийн 151.1.3 заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны "Хяналтын хуудас батлах тухай" А/540 дүгээр тушаалаар Согтyууpyулax yндaа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хэрэглэх 8.10.4 кодтой "Согтyууpyулax yндaагаар үйлчлэх хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг шалгах хяналтын хуудсыг баталсан. Тус хяналтын хуудасны 18, 19-т "Аяга таваг угаах 3 дамжлага бүхий угаалтуур, угаалтын автомат төхөөрөмжтэй, үйлчилгээний аяга таваг, халбага сэрээ хэрэгсэл ариутгах төхөөрөмжтэй" байна гэж заасан. Тус заалтын хэрэгжилтийг хангаж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2023 оны "Хяналт шалгалт хийх тухай" 08-00-02/28 дугаартай удирдамжаар бага эрсдэлтэй үнэлэгдсэн аж ахуйн нэгжид Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэгчийн ажлын байрны дүгнэлт олгохоор тусгасан. УБ хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/03, А/06, А/09,	100%

115

235	Худалдаа, үйлчилгээндээ нийгэм, байгаль орчинд ээлтэй техник, технологи, инноваци нэвтрүүлсэн, хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ.	-	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувиар	-	100	100%
A/16, A/28, A/40, A/42 тушаалаар 227 цэг, 9 дүүргийн 122 удаагийн захирамжаар 823 цэг, нийт 1050 цэгт Спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсоноос бүгд аяга таваг ариутгах төхөөрөмж нэвтрүүлсэн байна. Байгаль орчинд ээлтэй техник, технологи, инноваци нэвтрүүлсэн, хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлсэн, нийгмийн хариуцлагатай томоохон аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлтэй хамтран "Хүнс, Худалдаа, үйлчилгээний салбарын чиглэлээр төрөөс баримталж буй бодлого" сэдэвт 6 удаагийн уулзалтыг 2024 оны 08 дугаар сарын 21- 28-ны өдрүүдэд "Мах импекс"ХК, "Талх чихэр"ХК-ий байранд зохион байгуулахад Сонгинохайрхан дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нийт 300 орчим аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон. Мах импекс, Талх чихрийн гүйцэтгэх захирал шинэ дэвшилтэт техник, технологио танилцуулсан. Уулзалтад УБ хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Хүнс, худалдаа, үйлчилгээний газрын дарга, Хяналт, үнэлгээний газрын дарга, Нийслэлийн Татварын газрын Захиргааны хэлтсийн дарга нар дараах танилцуулгыг хийсэн. Үүнд: • Онлайн бизнес төвийн үйлчилгээ, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл; • Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл; • MNS 5021-1:2024 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, Ерөнхий шаардлага стандарт; • Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаар; • Хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдал;						

236	Үйлчилгээний дээшлүүлэх худалдаа эрхлэгч нэгжүүдийн дунд ажлын мэргэжлийн тэмцээнийг байгуулна. соёлыг зорилгоор аж ахуйн дунд ажил уралдаан, зохион байгуулна.	-	Уралдаан, тэмцээнд оролцсон аж ахуйн нэгжийн тоо	-	160	- Төр төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа; - Худалдаа, үйлчилгээний байгууллагын хариуцан ажиллах гадна орчны 50 метр талбайн цэвэрлэгээ үйлчилгээ; - Нийслэл хотын албан татварын талаар. Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойг угтан ахуйн үйлчилгээний салбарын орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг олон нийтэд сурталчлан таниулах, мэргэжлийн салбарын нэр хүндийг дээшлүүлэх, суралцагчдын ур чадварыг ахиулах, тэдний мэргэжлийн ур чадварыг олон улсад таниулах зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн "Ур чадварын тэмцээн" зохион байгуулах тухай" А/169 дүгээр тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд "МБЕАУ-2024" Олон улсын гоо сайхны ур чадварын тэмцээнд 184 оролцогч ур чадвараа сорьж 8 төрлөөр 121 аварга шалгаруулан, Нийслэлийн 385 жилийн ойн хүндэт медаль, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр салбартаа тэргүүлэн ажиллаж буй 4 гоо сайханчийг шагнаж, урамшуулсан.	100%
237	Зочлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	-	Хяналт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан үйлчилгээ эрхлэгчдийн тоо	-	250	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 52 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 2023- 2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарлах тухай 264 дүгээр тогтоолоор үндэсний хоол, хүнс судлалыг хөгжүүлэх, дэлхий нийтэд таниулах, үйлчилгээний соёл, онцлогийг түгээн дэлгэрүүлэх, төрөлжүүлэн хөгжүүлэх, ажлын байр болон аялал жуулчлалыг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зэрэг зорилтуудыг тус тус баталсан. Тус зорилтуудын хүрээнд	100%

						хамтран 2024 оны 10 дугаар сард Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 230 иргэн, аж ахуйн нэгжид сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.	
238	Үйлчилгээний дээшлүүлэх, хэрэглэгчдийн хэрэгцээ, нийцсэн нэвтрүүлэх, эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх нэмэгдүүлэх үндэсний ая тухтай дэлгүүр хөгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	•	Сургалт, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо	•	250	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/219 дүгээр захирамжаар Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс дүүргүүдийн Засаг дарга нарт шилжүүлсэнтэй холбогдуулан 9 дүүргийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Нийслэлийн нэгдсэн мэдээ мэдээллийн Улаанбаатар.mn цахим хуудасны "Онлайн бизнес төв"-өөр хүсэлт илгээх заавар зөвлөмжийг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл тус бүрээр байршуулан бизнес эрхлэгчдэд хүргэж байна.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/262 дугаар тушаалаар "Онлайн бизнес төв"-ийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системээр бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад үзүүлж буй цахим үйлчилгээ, түүнтэй холбоотой систем хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдон "Онлайн бизнес төв" 2.0 хувилбар платформыг нэвтрүүлэх ажлын техникийн даалгаварт төсөл боловсруулан санал хүргүүлээд байна. Монгол улсын Эдийн засаг хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/231 дүгээр тушаалаар Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүрээнд тусгай зөвшөөрөл	100%

						олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох зэрэг тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд эрх бүхий этгээдийн тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох, цахимжилтаар шийдвэрлэх чиглэлээр санал боловсруулах үүрэг бүхий холбогдох байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулсан ажлын хэсэгт ажиллаж, Соптууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ үзүүлэх, Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагааны процессын зураглал, дэлгэрэнгүй тайлбарыг загвар маягтын дагуу гаргаж, хүргүүлээд байна
Зорилт 74 Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй эрхлэх зориулалтаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд эзэмшүүлсэн газрын ашиглалтыг сайжруулж, малын халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.5.2						
239	Нийслэлд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд орж ирсэн малыг гаргах ажлыг зохион байгуулна.	-	Гүйцэтгэлийн хэрэгжилт, хувь	90	100	НИТХ-ын 2015 оны "Нийслэлд мал аж ахуй эрхлэх журам" батлах тухай 85 дугаар тогтоол, НИТХ-ын 2019 оны 21/06 "Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрөх буюу хориглох бүсийн хил хязгаарыг шинэчлэн батлах тухай" тогтоол дагуу Нийслэлийн Засаг даргын 2024.01.08-ны өдрийн А/07 дугаар захирамжаар нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах ажлын хэсэг, үйл ажиллагааны удирдамжийг баталсан. Захирамжийн хүрээнд Баянзүрх, Хан-Уул, Баянгол, Сүхбаатар, Цингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан 6 дэд ажлын хэсэг байгуулагдсан. УБ хотын Ерөнхий менежерийн баталсан 3 удаагийн хуваарийн дагуу НМЭГ, НХХААГ, НГЗБА, НБОГ, НОБГ, НЦУГ, ТЦА, төвийн 6 дүүргийн Засаг дарга, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн ОНӨААТҮГ, Богд хан уулын дархан цаазат газрын захиргаа, Дотоодын цэргийн 805 дугаар анги 17 байгууллагын 2357 албан хаагч, 358 тээврийн хэрэгсэл 102 морьт эргүүл 2024.01.12-ны өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдрийн хооронд

Хонхор чиглэл, Айдсын даваа чиглэл, Шар хөвийн дөрөлж, Морингийн даваа чиглэл, Шижирийн даваа чиглэл, Ар гүнт, Хадат вилла чиглэл, Гачуурт, Улиастай зэрэг нийт 6 чиглэлд ажиллаж, малчид, мал бүхий иргэдэд 56 мэдэгдэх хуудас, 249 албан мэдэгдэл өгч, 45 хоногийн хугацаанд нийт 19883 толгой малыг хориглосон бүсээс гаргасан. Журмын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/226 дугаар захирамжаар нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс малыг хашаанд түр саатуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал тууж хашаанд түр саатуулах ажиллагааны удирдамж, нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагуудын албан хаагчдыг мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг тууж түр саатуулах ажилд дайчлах 6 ажлын хэсгийн хуваарь батлагдсан. Ажлын хэсэг 2024.03.09-10-ны өдрүүдэд нийслэлийн 65 байгууллагын 2777, дотоодын цэргийн 260, цагдаагийн 120, морьт 12 эргүүл, Богд Хан уулын хамгаалалтын захиргааны 16, 6 дүүргийн харьяа байгууллагаас 1475, нийт 5325 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Нэгдсэн арга хэмжээний үеэр давхардсан тоогоор 5325 хүн хүч 86.6%-ийн ирцтэйгээр төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт самналт хийж, нутаг дэвсгэрт байгаа заагдсан мал хашаалах байрлалд тууж хашаалан эзэн холбогдогчид хариуцлага тооцуулах арга хэмжээг авч, Сонгинохайрхан дүүрэгт 4, Хан-Уул дүүрэгт 1, Баянзүрх дүүрэгт 2 байрлалд мал хашаалах хашааг бэлдэж малыг хашаалах ажлыг зохион байгуулсан бөгөөд нийт 3051 малыг илрүүлж, 56 иргэнд 56 зөрчлийн хэрэг үүсгэж хэргийн материалын
--

						бүрдүүлэлт хийснээс цагдаагийн байгууллага 18 зөрчлийн хэргийг шийдвэрлэсэн байна. Нийслэлд мал аж ахуй эрхлэх бүс, хориглосон бүс рүү нэвтэрсэн малыг хуулийн дагуу арга хэмжээ авах талаарх журмын танилцуулга, нэгдсэн арга хэмжээний хүрээнд олон нийт, иргэдэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр яриа, ярилцлагыг өгч ажиллалаа. Тухайлбал MNB, NTV телевиз болон 7 сайт (Ulaanbaatar.mn, news21.mn, sonin.mn, zms.mn, ulen.mn, time.mn, News Life.mn), зууны мэдээ болон өдрийн сонины 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн хэвлэлээр мэдээллэж ажиллаа. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсийн хил хязгаарыг тогтоож, журам батлах тухай" 09 дүгээр тогтоолоор нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглох бүсийн хил хязгаар, Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг түр хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх журам тус тус батлагдсан. Уг журмаар НМЭГ, НХХААГ удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахаар тусгагдсан.
Зорилт 75 Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний салбарын бодлогын хэрэгжилтийг хангахад төрийн болон ТББ-ын оролцоог сайжруулна.						
240	Дүүргүүдийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийг бодлогын зөвлөгөө, мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.	-	Үүрэг чиглэл хүргүүлж, зөвлөгөө өгсөн тоо	60	60	Хүнс, худалдаа, үйлчилгээний салбарын бодлогын хэрэгжилтийг хангах чиглэлээр дүүргүүдийн ЗДТГ-т үүрэг чиглэл хүргүүлж, бодлогын зөвлөгөө, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Тухайлбал: -Нийслэлийн Засаг даргын 2024.01.08-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/07 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах, хашаанд түр саатуулах ажлыг зохион байгуулахтай холбогдуулан УБ хотын Ерөнхий менежерийн баталсан 3 удаагийн хуваарийн дагуу төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт самналт

						хийж, Сонгинохайрхан дүүрэгт 4, Хан-Уул дүүрэгт 1, Баянзүрх дүүрэгт 2 байрлалд мал хашаалах хашааг бэлдэж, малыг хашаалах ажлыг зохион байгуулсан; -Нийслэлийн Засаг даргын 2024.01.22-ны өдрийн "Чиг үүрэг шилжүүлэх тухай" А/87 дугаар захирамжаар Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэж, бүртгэлийн гэрчилгээ олгох эрхийг дүүргийн Засаг дарга нарт шилжүүлсэнтэй холбогдуулан 9 дүүргийн мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх бүртгэлийн ажилтнуудад мэдлэг олгох сургалтыг 2024.03.19-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан; -Нийслэлийн Засаг даргын 2023.03.01-ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/219 дүгээр захирамжийг үндэслэн Дүүргүүд ажлын хэсэг байгуулж, захирамж, мэдээлэл тайланг улирал бүр ирүүлэх талаар 4 удаа үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан, дүүргүүдийн Дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн; -Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний байгууллагуудын орчны 50 м хүртэлх талбайн цас мөс, хогийг тогтмол цэвэрлүүлэх, хогийн сав, гадна фасад, хаяг, хаягийн байгууламж, хаалга, шат, цонх, зам талбайг цэвэрлэх, угааж чийгшүүлэх "Бүх нийтийн их цэвэрлэгээ", "Хаврын их цэвэрлэгээ", "Хотоо угаая" аянд бүрэн хамруулах талаар дүүргүүдэд үүрэг чиглэл хүргүүлж 2024.01.11-13-ны өдөр, 2024.02.28-ны өдөр, 2024.04.06,07-ны өдөр, 2024.04.13,14-ны өдөр, 2024.05.08-15-ны өдөр, 2024.10.12-ны өдөр, 2024.11.26-27-ны өдрүүдэд 7 удаагийн цэвэрлэгээний ажилд давамгайлсан тоогоор 31,976 иргэн, аж ахуйн нэгжийн 1,382,726 м2 талбайг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулсан;
--	--	--	--	--	--	---

-Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Электрон тамхи худалдан авагчдад насны хязгаар тогтоох тухай" захирамжийн хэрэгжилтийг хангаж Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг 18 насанд хүрээгүй хүүхдэд худалдан борлуулахгүй байх чиглэлээр худалдаа үйлчилгээний байгууллагуудад тогтмол хяналт тавьж ажиллах, хор уршиг, үр дагаврын асуудлаар сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг хэрэгжүүлэх талаар УБ хотын Ерөнхий менежерийн 2024.09.25-ны өдрийн 01/1826 дугаар албан бичгээр үүрэг чиглэл өгч хэрэгжилтийг хангуулсан; -МУИХ болон Орон нутгийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газрууд, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдэд хүргүүлэн, зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавьж ажиллах талаар УБ хотын ЕМ-ийн 2024.06.25-ны өдрийн 01/1357, 2024.10.09-ны өдрийн 01/1918 албан бичгээр үүрэг чиглэл хүргүүлсэн; -Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 09 дүгээр сарын А/151 дүгээр тушаалаар батлагдсан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас дүүргүүдэд шилжсэн хүнс, худалдаа, үйлчилгээний чиглэлийн үйл ажиллагаа болон салбарын хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт өгөх үүрэг бүхий ажлын хэсэг нийслэлийн 9 дүүргийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүүрэг тус бүрийн зөрчлийн тоон болон дэлгэрэнгүй мэдээлэл, цаашид анхаарах асуудал, зөвлөмжийг гаргаж, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн Зөвлөлийн хуралд танилцуулахаар Хяналт, үнэлгээний газарт хүргүүлээд байна. Үүнд:	
--	--

241	Хүнс, үйлчилгээний бодлогын хангах болон худалдаа, салбарын хэрэгжилтийг төрийн бус	-	Хамтарч ажилласан байгууллагын тоо	-	30	-Хүнс, худалдаа, үйлчилгээний чиглэлийн холбогдох хууль тогтоомж болон нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын хэрэгжилтийг хангаж, худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах -Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн үйл ажиллагаа, зохион байгуулалт -Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олголттой холбогдолтой үйл ажиллагаа, зохион байгуулалт, бүргэл мэдээллийн сан үүсгэсэн байдал, тэдгээрийн ашиглалт; -Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх бүртгэлийн гэрчилгээ олгохтой холбогдолтой үйл ажиллагаа, зохион байгуулалт, бүргэл мэдээллийн сан үүсгэсэн байдал, тэдгээрийн ашиглалт; - Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсийн салбарын бодлогын хэрэгжилт, цаг үеийн чанартай үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлагналт -Орчны 50 метрийн зураглалаар иргэн, ААНБ-ын тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах талбайг зааж, эзэнжүүлсэн, мэдээллийн сан үүсгэж, тогтмол баяжуулалт хийж, үр дүнд чиглэсэн ажил зохион байгуулсан ажил -Цахим системийн ашиглалтын байдал, холбогдох хууль, журмын хэрэгжилт, шийдвэрлэлтийн хугацаа -Хүнс, худалдаа, үйлчилгээний боловсон хүчин ба хүний нөөцийн нөхцөл байдал, бүтэц зохион байгуулалт, баримталж буй бодлого;	100%
	Хүнс, үйлчилгээний бодлогын хангах болон худалдаа, салбарын хэрэгжилтийг төрийн бус	-	Хамтарч ажилласан байгууллагын тоо	-	30	Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ бизнес эрхлэгчдийг дэмжиж хамтран ажиллах эрх зүйн таатай орчныг бүрдүүлж өгөх, тулгарч буй хүндрэлээс гарах гарц гаргалгаа, шийдлийг хамтдаа хэлэлцэж зөвлөлдөхөөр "Худалдаа,	

байгууллагуудтай хамтарч ажиллана.					үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам зөвлөлдөх уулзалт"-ыг 2024.04.11-ны өдөр НБИХГ-тай хамтран зохион байгууллаа. Арга хэмжээнд ХХААХҮЯ, НЗДТГ, ХСХГ, НТГ, НЭМГ, НХХААГ, НОБГ 9 дүүргийн ЗДТГ-ын холбогдох албан хаагчид оролцсон. Зөвлөлдөх уулзалтад нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа үйлчилгээний салбарын бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын 675 гаруй төлөөлөл оролцож, уулзалтын үеэр 22 оролцогч санал шүүмжлэлээ илэрхийлж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатараас хариулт тодруулга авсан бол цахим хэлбэрийн санал асуулгад 172 төлөөлөл оролцсон. Уулзалтаар гарсан санал болон асуултыг хариуцан ажиллах 24 заалт бүхий ажлын хуваарийг Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчоор батлуулан УБ хотын Ерөнхий менежерийн 2024.05.22-ны өдрийн 01/777 албан тоотоор хариуцан ажиллах 16 байгууллагад 24 төрлийн үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийн тайланг нэгтгэн УБ хотын Ерөнхий менежерт танилцуулсан. Түргэн үйлчилгээний цэгээр амь зуугчдын холбоо ГҮТББ -ын гишүүд болон хувиараа түргэн үйлчилгээний цэг эрхлэгч иргэдээс нийслэлийн төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй түргэн үйлчилгээний цэгүүдэд нийтийн эзэмшлийн гудамж, талбай чөлөөлөх мэдэгдэх хуудас хүргүүлж, цахилгааны эх үүсвэрийг салган, албадан нүүлгэж байгаа тухай ирүүлсэн хүсэлтийг судалж шийдвэрлэх хүртэл цахилгааны эх үүсвэрийг салгах, албадан нүүлгэх ажлыг түр хугацаанд зогсоох талаар чиглэлийг УБ хотын Ерөнхий менежерийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 01/911 тоот албан бичгээр дүүргүүдийн Засаг дарга нарт хүргүүлсэн. Төвийн 6 дүүргийн
------------------------------------	--	--	--	--	---

						нутаг дэвсгэрт 2022 оны сүүлийн байдлаар 1796 ТҮЦ үйл ажиллагаа явуулж байсан бол 2024 оны 12 дугаар сарын байдлаар 659 ТҮЦ-ийг нүүлгэж, 1143 ТҮЦ үйл ажиллагаа явуулж байна. Дүүргүүд Засаг даргын захирамж гарган нийтийн эзэмшлийн зам талбайд иргэдийн явган зам дээр байршсан, замын хөдөлгөөний үзэгдэх орчныг хаасан, ногоон байгууламж дээр байршуулсан зэрэг иргэдийн ая тух, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй 659 ТҮЦ-ийг нүүлгэж нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлсөн байна. Нүүлгэлтийн ажил хийгдэх үед төрийн албан хаагчдын тавьсан шаардлагын биелүүлэхгүй эсэргүүцэл үзүүлж, нүүлгэлтийн ажилд саад учруулах бусад ТҮЦ эзэмшигчтэй барьцах зэрэг хүндрэлүүд гарч байна.					Үнэлэ х болом жгүй.
242	Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн дэд хөтөлбөр боловсруулна.	-	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	-	100	Чиг үүргийн дагуу НХХААГ болон Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв					
Зорилт 76 Иргэдэд зориулсан үзэсгэлэн худалдаа, өргөтгөсөн худалдаа, бусад арга хэмжээ зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах											
243	Баяр ёслол, тэмдэглэлт өдрийн үеэр иргэдэд зориулсан худалдаа, үйлчилгээ зохион байгуулна.	-	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	-	100	1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/39 дүгээр захирамжаар нийслэлийн 9 дүүрэгт "Сар шинийн баярт зориулсан өргөтгөсөн худалдаа" зохион байгуулах 17 байршлыг баталж "Шинэ зуун айл", "Баялаг ундраа", "Мишээл экспо", "Дүнжингарав" худалдааны төв, "Улаанбаатар палас", "Хүннү молл" их дэлгүүр, Үйлдвэрчний эвлэлийн Соёлын төв ордон, Тусгаар тогтнолын талбай гэх мэт томоохон худалдааны төв, гадна талбайд 1500 гаруй үндэсний үйлдвэрлэгч, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулан	100%				

						мах, цагаан идээ болон бусад хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг нэг дороос өргөн сонголтоор худалдан авах боломжийг бүрдүүлж, замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ТЦА-ны ЗЦГ, НЦУГ, НЭМГ, НМЭГ, НХХААГ, "Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв" НӨҮГ, 9 дүүргийн ЗДТГ-тай хамтран өргөтгөсөн худалдааг зохион байгуулж ажилласан. 2."Улаанбаатар марафон-2024" олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулахтай холбогдуулан дүүргүүдийн иргэдэд үйлчилгээ үзүүлэх байршил, үйл ажиллагааны чиглэл, "Автомашингүй өдөр"-өөр амрах 20 зах, худалдаа, үйлчилгээний төвүүдийн жагсаалтыг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/574 дүгээр захирамжаар батлуулж, 2024.05.25-ны өдөр арга хэмжээний үеэр НХХААГ, НЭМГ, НЦУГ, НОБГ, дүүргүүдийн ЗДТГ-тай хамтран нийт 26 албан хаагч Д.Сүхбаатарын талбайд худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд хяналт тавьж ажилласан. 3."Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонгийн гардуулах ёслолын арга хэмжээ 2024.05.20-ны өдрөөс 2024.05.24-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, арга хэмжээний үеэр Жанжин Д.Сүхбаатарын талбайд хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 16, хүнсний худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 4, нийт 20 иргэн, аж ахуйн нэгжийг улирлын чанартай түр сүүдрэвчтэй худалдаа, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны түр цэгийг гаргах ажлыг зохион байгуулсан. 4.Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/526 дугаар захирамжаар Сонгинохайрхан дүүрэг, 21 дүгээр хороо, Хүй долоон худагт Монгол улсын уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болон зан
--	--	--	--	--	--	---

						заншлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, нийслэл Улаанбаатар хотын олон улсад сурталчлах зорилгоор "Тэнгэр" олон улсын бөөгийн фестиваль 2024.05.24-ний өдрөөс 2024.05.27-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулагдсан ба тус арга хэмжээнд 17 явуулын үйлчилгээтэй түргэн хоолны түр цэгээр хоол үйлдвэрлэл үйлчилгээг зохион байгуулж, хяналт тавьж ажилласан. 5.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, Ерөнхий сайд А.Амарын гудамжинд хүүхдэд зориулсан худалдаа, үйлчилгээг зохион байгуулахад нийт 90 асарт зайрмаг, ус ундаа хоол үйлдвэрлэл үйлчилгээ гаргаж, явуулын үйлчилгээтэй 25 хоолны газрыг худалдаа үйлчилгээ үзүүлсэн. Мөн "Иргэний сонголт эрүүл хүнс" 33 секундийн контентыг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан. 6.Тулгар төрийн 2233, Их Монгол Улсын 818 жил, Үндэсний эрх чөлөө, Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой Үндэсний их баяр наадмын худалдаа үйлчилгээг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн "Үндэсний их баяр наадмын үеэр худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих тухай" А/120 дугаар тушаалаар Төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй долоон худагт худалдаа, үйлчилгээ зохион байгуулах, хяналт тавих, ажлын удирдамж, худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавигдах шаардлага, схем зураг, хог хаягдлын төлбөрийн хураамжийн тарифыг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаа. 7.2024-2025 оны хичээлийн шинэ жилийг угтан сурагч, оюутан, эцэг, эхчүүдэд ойрхон, хүртээмжтэй, харьцангуй хямд үнээр хичээлийн хэрэгсэл, дүрэмт хувцас, шаардлагатай бусад хувцас хэрэгслийг нэг дороос өргөн сонголтоор
--	--	--	--	--	--	---

						худалдан авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны А/134 дүгээр тушаалаар үзэсгэлэн худалдаа зохион байгуулах 9 дүүргийн 16 байршлыг баталж нийт 255 цэгээр хичээлийн шинэ жилийн өргөтгөсөн худалдаа зохион байгуулсан. 8.Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 344 дүгээр тогтоолоор стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлж байхыг аймаг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосны дагуу "Өвлийн идэш" арга хэмжээг "Хоршоологчдоос хотынхондоо" уриан доор зохион байгуулах тухай танилцуулгыг "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий салбар дундын уялдааг хангах Үндэсний хорооны ажлын албанд хүргүүлж Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдааны 40 дүгээр тэмдэглэлээр үүрэг болгосон. Тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024.11.28-ны өдрийн А/188 дугаар тушаалаар "Хоршоологчдоос хотынхондоо" уриан доор хэрэгжүүлэх "Өвлийн идэш" өргөтгөсөн худалдаа зохион байгуулах 8 байршлыг баталж, ажлын хэсгийг байгуулсан. Тус байршлуудад халуун хоол цайгаар үйлчилгээ үзүүлэх явууллын үйлчилгээтэй түргэн хоолны түр цэг гаргаж, хяналт тавьж ажиллахыг дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэст үүрэг болгосон. 9. Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдах "Мөнгөн шөнө" арга хэмжээний үеэр иргэдэд "Христмас маркет" худалдаа үйлчилгээ зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Төлөвлөгөө болон план зураг, шаардагдах төсвийн тооцооллыг гаргаж НЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтэс, нийслэлийн Соёл урлагийн газар хүргүүлсэн.
--	--	--	--	--	--	--

244	Ардын хувьсгалын 103 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр “Хөхүүрийн айраг” арга хэмжээ зохион байгуулна.	34.0 сая төг	Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	-	100	Үндэсний их баяр наадмын үеэр Хүй долоон худгийн үйлчилгээний талбайд СБД, БГД, СХД, Монгол наадам цогцолбор худалдааны 173, хоол үйлдвэрлэл үйлчилгээ /хуушуур/-ний 197 цэг, Төв цэнгэлдэх хүрээлэнд ХУД, ЧД, БЗД, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв нь худалдааны 63, хоол үйлдвэрлэл үйлчилгээ /хуушуур/-ний 177 цэг, Хүй долоон худгийн Соёл урлагийн талбайд гар урлал, бэлэг дурсгал, соёлын барааны худалдаа 65 цэг, хөдөлгөөнт тоглоомын 20 цэг, кофе шолын 5 цэг нийт 610 цэгийн байршлын схем зургийн дагуу худалдаа, үйлчилгээг төлөвлөн бэлтгэл ажлыг хангасан. “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем”-ээр Үндэсний их баяр наадмаар Төв цэнгэлдэх хүрээлэн болон Хүй долоон худгаг худалдаа, үйлчилгээ эрхлэх хүсэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 07:00 цагаас 07 дугаар сарын 03-ны өдрийн 16:00 цаг хүртэл төрийн үйлчилгээний нэгдсэн Ulaanbaatar.mn портал системээр нийт 1188 хүсэлт хүлээн авснаас Хүй долоон худгаг 554, Төв цэнгэлдэх хүрээлэнд 634 иргэн, аж ахуйн нэгж үйлчилгээ эрхлэх хүсэлт ирүүлснээс тавигдах шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн 370, хүнсний худалдаа 110, хүнсний бус худалдаа, жижиг дунд үйлдвэрлэл болон хөдөлгөөнт тоглоомын үйлчилгээ 130, нийт 610 хүсэлтийг шийдвэрлэн, худалдаа, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зориулсан “Зөвлөмж” өгсөн. 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс 13-ны өдрийн хооронд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ХХҮГ-ын дарга нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, төвийн 6 дүүргийн Засаг даргын Тамгын газрын ХХҮХ-ийн 38, Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын 6, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв НӨҮТ 18 албан хаагчид зохион байгуулалтын ажлыг хийж, нийслэлийн Хүнс,
						100%

						хөдөө, аж ахуйн газрын 45 улсын (ахлах) байцаагч, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 46 улсын байцаагч, нийслэлийн Мал эмнэлгийн газрын 28, нийт 98 улсын байцаагч хяналт тавин ажилласан. Төв цэнгэлдэх болон Хүй долоон худагт худалдаа, үйлчилгээ гаргах талбайн хуваарилалтыг сугалааны журмаар явуулж, бүх газруудыг цагаан асар, гэр болон Үндэсний баяр наадам, нийслэл, дүүргийн лого бүхий нэгдсэн хаягаар жигдрүүлж, план зургийн дагуу байршуулсан. Үйлчилгээний ажилтнуудыг цагаан өнгийн цамц /футболк/ болон нэг загварын ажлын хувцсаар жигдрүүлсэн, үйлчлүүлэгчдэд гар ариутгах бодисыг бэлтгэж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж ажилласан. Төв цэнгэлдэх хүрээлэнд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжүүд асфальтан талбай дээр байрлаж, асар майхны дор шалавч болон хулдаасыг дэвсэж тоос шороо босохоос сэргийлж, эрүүл ахуйн шаардлага хангаж ажилласан.
Зорилт 77 Хэрэглэгчдийн хоол хүнсний талаарх мэдлэг боловсролыг дээшлүүлж, эрүүл, зөв, зохистой хэрэглээний дадлыг нэвтрүүлэх						
245	"Хоолны фестиваль" зохион байгуулна.	-	Хоол хүнсний зөв, зохистой хэрэглээг сурталчлан таниулсан иргэдийн тоо	-	500	Европын Холбооны санхүүжилттэй "Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь" төслийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Дотор махны өдөр-ийг тэмдэглэн, дотор махны нөөц, үйлдвэрлэл, зах зээл, хэрэглээний талаар мэдээлэл солилцон, цаашдын боломжуудыг хэлэлцэх арга хэмжээг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголын Махны Холбоо болон Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуультай хамтран Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо, Blue Sky Tower, 3 давхрын Diamond Танхимд зохион байгуулахад

			таниулсан иргэдийн тоо			2024 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал 2 хоногийн хугацаанд Баянзүрх дүүргийн 26-р хороо, Үндэсний соёл амралтын хүрээлэнд "Солонгосын өдрүүд- хоолны фестивал" арга хэмжээг хамтран зохион байгуулсан. Тус арга хэмжээд Солонгос үндэсний хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 14 иргэн, аж ахуйн нэржийг хамруулсан.	95.42 %
78 зорилтын 247 арга хэмжээний дундаж үнэлгээ							

Биелэлт хянасан:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА

/Н.ОТГОНБАЯР/

Биелэлт гаргасан:

АЛБАНЫ БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХАРЬА БАЙГУУЛЛАГЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

/Ч.БАТТУЛГА/